



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.8 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хуулийн этгээд (3)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
110 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөр -лийн дугаар	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Тусгай зөвшөөр -лийн хугацаа	Дуусах хугацаа
1	“Гайхмаар хурд” ХХК	23700045	Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэрт Утасгүй интернэтийн үйлчилгээнд Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах	10 жил	2036.07.07
2	“Кевико” ХХК	23700049	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Утасгүй интернэтийн үйлчилгээнд Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах	10 жил	2036.08.25
3	“Монголын цахилгаан холбоо” ХК	23410037	Баян-Өлгий аймгийн Өлгий сум; Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум; Дорнод аймгийн Хэрлэн сум; Өвөрхангай аймгийн Арвайхээр сум; Өвөрхангай аймгийн Хархорин сум; Увс аймгийн Улаангом сум; Хөвсгөл аймгийн Мөрөн сум; Хэнтий аймгийн Бор- Өндөр, Хэрлэн сумууд; Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт Тоон телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээнд Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах	10 жил	2036.08.25

----- оОо -----